

Зах зээлд эзлэх хувь /Нийт актив/



Салбарын үзүүлэлтүүд /их наяд төгрөг/

Үзүүлэлт	2024	Өөрчлөлт
Нийт актив	71.4	25%
Зээлийн үлдэгдэл	36.8	35%
Пассив	64.1	25%
Харилцах, хадгаламж	39.6	13%
Хадгаламж	25.6	21%
Өөрийн хөрөнгө	7.3	30%
Цэвэр ашиг	1.7	38%

Системийн банкуудын үзүүлэлтүүд

	ROA	ROE	P/B	Нийт хөрөнгө*	Цэвэр ашиг*
Khan	3.2%	26.3%	0.9	20,302.7	638.5
TDB	2.0%	20.3%	0.9	15,016.0	300.1
GLMT	2.6%	32.1%	0.8	15,410.2	407.3
SBM	1.7%	17.1%	0.6	6,218.5	108.0
ХАС	2.7%	25.6%	1.2	6,317.7	170.8

*тэрбум ₮

БАНКНЫ САЛБАР

Салбарын ерөнхий төлөв

Монгол Улсын банкны салбар 2024 онд тогтвортой өсөлттэй байж, зээлийн багц болон нийт активын хэмжээ нэмэгдсэн. Чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 10 жилийн доод түвшинд хүрч, санхүүгийн тогтвортой байдал сайжирсан. Нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 25 хувиар өсөж 71.4 их наяд төгрөгт хүрсэн. Нийт активын 49 хувь буюу 36.8 их наяд төгрөгийг цэвэр зээл бүрдүүлж байгаа ба өмнөх жилийн мөн үеэс 38 хувиар өссөн байна. Нийт пассивын хэмжээ 25 хувиар өсөж 64.1 их наяд төгрөгт хүрсэн. Хадгаламж ба харилцааны дүн 13 хувиар өсөж 39.6 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт пассивын 62 хувийг эзэлжээ.

2024 оны онцлох үйл явдлууд:

- Moody's, S&P, Fitch агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг ахиулсан.
- Олон улсын Apple pay төлбөрийн систем нэвтрүүлэх орчин бүрдсэн.
- "Хаан Банк" ХК, "Төрийн Банк" ХК, "Худалдаа Хөгжлийн Банк" ХК нар дотоод болон олон улсын зах зээл дээр ногоон бонд гаргасан.
- Монголбанк болон Хятадын ардын банк хооронд байгуулсан "Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээ"-ний ашиглалтын үлдэгдлийг 2 дахин буурууллаа

Системийн 5 банкны төлөв байдал

2024 оны системийн банкуудын үзүүлэлтээс харахад ROA (активын өгөөж) дунджаар 2.44%, ROE (өөрийн хөрөнгийн өгөөж) 24.28%-тай байв. P/B харьцаа 0.88 байгаа нь банкуудын хувьцааны үнэ бодит үнэ цэнээс бага зэрэг доогуур байгааг харуулж байна. Цэвэр ашгийн дундаж 324.9 тэрбум төгрөг, харин дундаж нийт хөрөнгө 12.7 их наяд төгрөг байна.

Банк	IPO ханш	2025.02.06 ханш	Өөрчлөлт
Khan	959₮	1,200₮	+25%
TDB	33,000₮	24,000₮	-27%
GLMT	1,285	1,290₮	+0.4%
SBM	590₮	516₮	-13%
ХАС	677₮	822₮	+21%

Зээлийн үлдэгдэл /их наяд төг/

Нийт зээл /салбараар/

Чанаргүй зээлийн хувь /салбараар/

Нийт зээлийн ангилал

НИЙТ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

2020 онд 17.03 их наяд төгрөг байсан бол энэ тоо тасралтгүй өсөж, 2024 онд 36.78 их наяд төгрөг болж, сүүлийн 5 жилийн дотор бараг хоёр дахин нэмэгдсэн бөгөөд жилийн дундаж өсөлт /CAGR/ 17 хувь байна. Энэ нь банкны салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөө өсөн нэмэгдэж байгааг илтгэнэ. Жил бүрийн өсөлт нь тогтвортой бөгөөд зээлийн эрэлт хэрэгцээ болон эдийн засгийн идэвхжил өндөр байгааг илэрхийлж байна.

НИЙТ ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

2020 онд зээлийн нийт дүнгийн 12% нь чанаргүй байсан бол энэ үзүүлэлт тогтвортой буурч, 2024 онд 5% болжээ. Энэ нь банкны салбарын зээлийн чанар сайжирч, эрсдэлийн удирдлагын арга хэмжээ үр дүнгээ өгч байгааг харуулж байгаа ба чанаргүй зээлийн бууралт нь банкны салбарын тогтвортой байдлыг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

НИЙТ ЗЭЭЛ /САЛБАРААР/

2024 оны байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 17 хувь буюу 6.2 их наяд төгрөгийг цалингийн зээл эзэлж байна. Цалингийн зээлийн чанаргүй зээлийн хувь 3.4 хувьд хүрсэн бөгөөд цар тахлын үеэс хойш тогтмол буурж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын зээлийн үлдэгдэл нийт зээлийн үлдэгдлийн 17 хувь буюу 6.4 их наяд төгрөгийг эзэлж байна. Тус салбарын зээлийн чанаргүй хувь нийт зээлийн үлдэгдлийн чанаргүй зээлийн хувьтай харьцуулахад бага бөгөөд 2024 оны байдлаар 3.8 хувь болж өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл нийт зээлийн үлдэгдлийн 16 хувь буюу 5.8 их наяд төгрөгийг эзэлж байна. Тус салбар бусад салбартай харьцуулахад чанаргүй зээлийн хувь хамгийн бага буюу 1.6 хувьтай байна. 2020 онд тус салбарын чанаргүй зээлийн харьцаа 9.1 хувь байсан бол 5 жилийн дөтөр 7.5 хувиар буурсан байна.

Уул уурхайн салбар Монголын эдийн засгийн тулгуур салбар хэдий ч нийт зээлийн үлдэгдлийн ердөө 7 хувийг эзэлж байна. Энэ нь уул уурхайн томоохон төслүүдийн санхүүжилт гадаад эх үүсвэрээс хамааралтай байдагтай холбоотой. Тус салбарын чанаргүй зээлийн хувьд бусад салбартай харьцуулахад харьцангуй өндөр (9%) хэдий ч 2020 оноос хойш тогтмол буурж байна.

ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ

2024 оны байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 60 хувь буюу 22 их наяд төгрөгийг иргэдийн зээл эзэлж байна. 37 хувь буюу 13.8 их наяд төгрөгийг хувийн байгууллагын зээл, 1 хувь буюу 590 тэрбум төгрөгийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл, 1 хувь буюу 460 тэрбум төгрөгийн улсын байгууллагуудын зээлүүд тус тус эзэлж байна.

Иргэдийн зээлийн үлдэгдэл /их наяд төг/



Иргэдийн зээлийн задаргаа



Ипотекийн зээлийн үлдэгдэл /их наяд төг/



Ипотекийн зээлийн санхүүжилт



ИРГЭДИЙН НИЙТ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

2024 оны байдлаар нийт иргэдийн зээлийн үлдэгдэл 22 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 43 хувиар өсжээ. 2020 онд 8.5 их наяд төгрөг байсан ба жилийн дундаж өсөлт /CAGR/ 26 хувьтай байна. Уг 43 хувийн өсөлтөд бодлогын хүү 13 хувиас буурж 10 хувь болсон нь гол нөлөөг үзүүлжээ.

Мөн иргэдийн зээл сүүлийн 5 жилийн хугацаанд 2.6 дахин өссөн. Гэсэн хэдий ч чанаргүй зээлийн хувь 5.8%-аас 6.8% болж нэмэгдсэн нь зээлийн чанар муудаж буйг харуулж байна. Уг чанаргүй зээлийн өсөлтөд инфляцийн өсөлт нөлөөлжээ.

ИРГЭДИЙН ЗЭЭЛИЙН ЗАДАРГАА

Нийт иргэдийн зээлийн ихэнх хэсгийг цалингийн, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны, тэтгэврийн, бөөний болон жижиглэн худалдааны зориулалттай зээлүүд бүрдүүлж байна. Зээлийн 26 хувь буюу 6.3 их наяд төгрөгийг цалингийн зээл эзэлж байгаа бөгөөд өмнөх жилийн мөн үеэс 47 хувийн өсөлт үзүүлжээ.

Нийт тэтгэврийн зээл 7 хувь буюу 1.6 их наяд төгрөгийг эзэлж байгаа ба 2023 оноос 38 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Жижиглэн болон бөөний худалдааны зориулалтын зээлийн дүн 2.4 их наяд төгрөг буюу 11 хувийг эзэлсэн бөгөөд 37 хувиар өссөн.

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зориулалттай зээл 24 хувийг буюу 5.5 их наяд төгрөгийг бүрдүүлсэн ба өмнөх жилийн мөн үеэс 49 хувиар өссөн.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

Ипотекийн зээлийн үлдэгдэл 2020 онд 4.9 их наяд төгрөг байсан бол 2024 онд 9.4 их наяд төгрөгт хүрч, нийт 91.8%-ийн өсөлттэй байна. Энэ нь жилийн дундаж өсөлт 18.4%-тай байгааг илэрхийлж байна.


Ипотекийн зээлийн тогтвортой өсөлт нь орон сууцны хэрэгцээ, барилгын салбарын хөгжил, ипотекийн зээлийн хүүгийн бодлогын нөлөөллийг харуулж байна. Чанаргүй зээлийн хувь 2020 онд 3% байсан бол 2024 онд 1% болж буурсан нь ипотекийн зээлийн эргэн төлөлтийн чадвар сайжирч, ипотекийн жилийн хүү 8 хувиас 6 хувь болсон мөн цар тахлын үеэс ипотекийн зээлийн төлөлт зогссон зэрэг нь эерэг нөлөөг үзүүлжээ.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ


2024 оны байдлаар нийт ипотекийн зээлийн 41 хувь буюу 4.1 их наяд төгрөгийг МИК /Монголын Ипотекийн Корпораци/ бүрдүүлж байгаа бол ОСИСТТБ хөтөлбөрийн эх үүсвэр 21 хувийг буюу 2 их наяд төгрөгийн эзэлж байна. Банкны эх үүсвэр 21 хувь буюу 3.2 их наяд төгрөгийг эзэлж байна. Өсөлтийн хувьд өмнөх оны мөн үеэс банкны эх үүсвэр 36 хувь, ОСИСТТБ-ийн хөтөлбөрийн эх үүсвэр 84 хувь, МИК-ийн зээл 1 хувийн өсөлт үзүүлжээ.

САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ


ROA, ROE /хувиар/



Ашгийн үзүүлэлтүүд /их наяд төг, хувиар/



Эрсдэлийн сангийн хүрэлцээ



АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД /ROA, ROE/

2024 онд банкны салбарын нийт хөрөнгийн өгөөж /ROA/ өмнөх жилийн мөн үеэс 0.3 хувиар нэмэгдэж 2.7 хувь болж өсжээ. Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/-ийн хувьд 2024 оны байдлаар 1.8 хувиар өссөн бөгөөд 26.5 хувь болсон байна. Тус үзүүлэлтүүд өсөхөд нийт цэвэр ашиг 38 хувиар нэмэгдсэн нь гол шалтгаан болов.

Хүүгийн орлогын маржин

Хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 24 хувиар өсөж 3.1 их наяд болсон үзүүлэлттэй байна. 2024 оны эцсийн байдлаар хүүгийн орлогын маржин 4.8 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурсан байна. Хүүгийн маржин буурсанд бодлогын хүүгийн бууралт нөлөөлжээ.

Цэвэр ашгийн маржин

Цэвэр ашгийн хэмжээ 38 хувиар өсөж 1.7 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд цэвэр ашгийн маржин өмнөх оны мөн үеэс 1 хувиар өсөж 27 хувьд хүрсэн. Уг өсөлтөд системийн 5 банкны цэвэр ашиг өссөн, зээлийн хэмжээ нэмэгдсэн, эдийн засгийн өсөлт гэх мэт зүйлүүд нөлөөлжээ.

ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ

Эрсдэлийн сангийн хүрэлцээ (NPL coverage ratio) нь 100 хувиас дээш байвал Банк нь чанаргүй зээлээ бүрэн нөхөх хангалттай эрсдэлийн сантай байна гэж үздэг. 2022 оноос хойш нийт банкны салбарын хувьд тус харьцаа нь 100 хувиас дээш гарсан бөгөөд 2024 оны байдлаар 124 хувьтай байна. Банкнууд чанаргүй зээлтэй холбоотой эрсдэлийг нөхөхөд хангалттай эрсдэлийн сантай байгааг уг харьцаа үзүүлэлт харуулж байна.

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД /СИСТЕМИЙН 5 БАНК/

	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ
Khan	44.52%	17.77%
SBM	38.81%	18.21%
TDB	49.52%	14.80%
ХАС	38.40%	19.20%
GLMT	35.42%	14.67%

ДҮГНЭЛТ

2024 онд Монголын банкны салбарын ашигт ажиллагаа, тогтвортой байдалд эерэг ахиц гарсан байна. Цэвэр ашиг, нийт хөрөнгийн өгөөж, нийт өөрийн хөрөнгийн өгөөж зэрэг голлох үзүүлэлтүүдийн өсөлт нь салбарын эдийн засгийн өсөлт, зээлийн хэмжээний нэмэгдэл, мөн банкуудын үр ашигтай удирдлагаас хамааралтай байв. Хэдийгээр хүүгийн маржин бага зэрэг буурсан ч цэвэр ашгийн өсөлт, чанаргүй зээлийн эрсдэлийг нөхөх хангалттай сан бүрдүүлжээ. Мөн системийн 5 банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай түвшинд байна.